

2022 ОНЫ 12 ДУГААР САР

“ШҮҮХИЙН УРЬДЧИЛСАН ХЭЛЭЛЦҮҮЛЭГ” ТЭМДЭГЛЭЛ

АРГА ЗҮЙ

Нээлттэй Нийгэм Форум нь эрх зүйн шинэчлэлийн үйл явцыг бодлогын хэлэлцүүлэг, судалгаагаар дэмжиж ажиллахыг зорьдог билээ. Энэ хүрээнд хүний эрхэд суурилсан, шударга процесс бүхий эрүүгийн эрх зүйн шинэчлэлийг гүнзгийрүүлэхэд хувь нэмэр оруулах зорилгоор “Эрүүгийн процесс ба Хүний эрх” цуврал хэлэлцүүлгийг эхлүүллээ. Эдгээр хэлэлцүүлэг нь Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хэд хэдэн хуулийн төслийг УИХ хэлэлцэж байгаа үетэй давхцаж буйгаараа онцлог юм. Цуврал хэлэлцүүлгийн зорилго эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх шатанд тулгамдаж буй хүний эрхийн асуудлыг хөндөхөд оршиж байгаа бөгөөд хэлэлцүүлгийг ХЭҮК, ХЗДХЯ, МХХ, МӨХ-той хамтран зохион байгуулж байгаа билээ. Энэ удаагийн хэлэлцүүлэг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 33.1 дүгээр зүйлд зохицуулсан шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийн хүрээнд өрнөсөн бөгөөд түүний тэмдэглэлийг сийрүүлэн Та бүхэнд хүргэж байгаадаа баяртай байна.

ШҮҮХИЙН УРЬДЧИЛСАН ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

ЕРӨНХИЙ ТОЙМ

Эрүүгийн эрх зүйн шинэчлэл 1993 оноос эхэлж, энэ хугацаанд хоёр удаа эрүүгийн хууль тогтоомжийг шинэчлэн найруулж баталсан бөгөөд шинэчлэлийг гүнзгийрүүлэх ажил үргэлжлэн явагдаж байна. Шинэчлэлийн хүрээнд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх явцад бий болсон шинэлэг алхмын нэг бол шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг юм. Шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг нь хэрэг хянан шийдвэрлэх явцад хүний эрх зөрчигдөхөөс сэргийлэх тун чухал хамгаалалт боловч талууд үүнийг үр дүнтэй ашиглаж чадаж байгаа эсэх нь эргэлзээтэй байна. Энэ талаар Нээлттэй Нийгэм Форумгаас хийсэн судалгааны тайланд тодорхой дурдсан.¹ Энэ хэлэлцүүлгээр бид тулгамдаж буй асуудлыг тодорхойлж, шийдвэрлэх арга замыг эрэлхийлэхийг зорилгоо.

¹ Г.Эрдэнэбат, Г.Оюунболд, Ц.Арилдийпүрэв. Шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг. “Эрх зүйн шинэчлэл: Зарим асуудал (Бодлогын судалгааны эмхэтгэл)”, Нээлттэй Нийгэм Форум, УБ., 2020, http://www.forum.mn/res_mat/2020/ErkhZuinemkhetgel.pdf

“ХУУЛИЙН ӨМНӨ” ЖҮЖГИЙН ТАНИЛЦУУЛГА²

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны процессын шударга байдлыг хангахын тулд шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг хэмээх зохицуулалтыг хуульд оруулж ирсэн. Хэдийгээр бусад улсынхтай адил мөрдөн шалгах ажиллагааны эхний шатнаас урьдчилсан хэлэлцүүлэг явуулах нөхцөл хангагдаагүй ч мөрдөн шалгах ажиллагаа дуусаж, тухайн хүний гэм буруугийн асуудлыг шийдвэрлэх боломжтой боллоо гэсэн үед мөрдөн шалгах ажиллагаа шударга, хуулийн дагуу явагдсан эсэхийг эргэн хянаж, энэ шатанд ямар нэгэн алдаа гарсан, хууль бус ажиллагаа явагдсан бол түүнийг таслан зогсоох, зөвтгөх, залруулах, засах, эсвэл ямар ч боломжгүй бол хууль бус ажиллагааг бүхэлд нь хүчингүй болгох зорилгоор шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг хэмээх зохицуулалт бий болгосон. Энэ нь 1963 оны Эрүүгийн байцаан шийтгэх хуульд байсан шүүхийн хянан магадлах хуралтай төстэй. Гэхдээ илүү дэвшилттэй зохицуулалт юм. Шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгээр шүүхийн алдаа, мөрдөн шалгах ажиллагааны явц дахь хууль бус ажиллагаа, хууль бус аргаар нотлох баримт цуглуулсан нь засагдах боломжгүй бол хууль бус уг ажиллагааг хүчингүй болгох бөгөөд энэ нь шалгуулж, буруутгагдаж байгаа хүндээ ашигтайгаар шийдвэрлэгдэнэ. Жишээлбэл, шүүхээс хэргийг прокурорт буцаах буюу мөрдөн шалгах ажиллагааг дахиж хийлгэх процесс байж болохгүй. Үндсэндээ хүний гэм бурууг хэлэлцэж байснаа хангалттай нотлох баримт бүрдээгүй гэсэн үндэслэлээр "Дахиад шалгаад ир" гэх нь шударга шүүхээр шүүлгэх эрхийг нь зөрчсөн хэрэг юм. Гэтэл нөгөө талдаа "хангалттай баримтгүй" гэсэн үндэслэлээр хохирогчийг хохироож, яллагдагчид ял завших боломж бий болгоно гэсэн болгоомжлол байна. Тиймээс энэ алдааг гаргахгүй байх үүднээс тухайн хүн гэм буруутай юу, үгүй юү гэдгийг шүүхээр хэлэлцэхээс өмнө мөрдөн шалгах ажиллагаа хуулийн дагуу явсан эсэх, нотлох баримт цуглуулахдаа ямар нэг байдлаар хууль зөрчсөн эсэх, шударга бус ажиллагаа явагдсан эсэхийг шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгээр хэлэлцэж, хэргийг прокурорт буцаах боломж олгосон.

Гэм буруугийн асуудлыг хэлэлцэх хурлаас хэргийг прокурорт буцаах асуудлыг халах нь хохирогчийг хохироож, гэмт этгээдэд ял завших эрсдэл үүсгэж байгаа гэх нь өрөөсгөл ойлголт юм. Учир нь гэм буруугийн асуудлыг хэлэлцэхээсээ өмнө процесс дахь дутуу, буруу хийгдсэн ажиллагааг засаж залруулах, хууль бус нотлох баримтуудыг хасах, хүчингүй болгох, мөрдөн

² Б.Хишигсайхан, Д.Энхболдбаатар. "Хуулийн өмнө" теле жүжиг. Нээлттэй Нийгэм Форум, Глоб Интернэшнл төв, МҮОНТ, https://www.youtube.com/watch?v=wCKviTXAzBk&ab_channel=OpenSocietyForum-Studio

шалгах ажиллагааны явцад орхигдуулсан зүйлийг гүйцээх нь шударга ёсонд нийцэх бөгөөд шүүхийн алдаанаас зайлсхийх маш том боломж, үүнийг шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг олгодог. Өөрөөр хэлбэл, шударга шүүхээр шүүлгэх эрхийг хангахад шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг онцгой үүрэгтэй. Гэвч шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг энэ зорилгыг хангаж чадахгүй байна. Тиймээс шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг хийхэд ямар хүндрэл байгаа, эрх зүйн орчныг хэрхэн сайжруулах зэрэг асуудлыг хэлэлцэх нь чухал ач холбогдолтой.

Өмгөөлөгчдийн хувьд урьдчилсан хэлэлцүүлэгт оролцох нь хуулиар олгосон маш том боломж хэдий ч судалгаанаас харахад нийт урьдчилсан хэлэлцүүлгийн 60 орчим хувьд өмгөөлөгчийг оролцуулахгүйгээр шийджээ. Шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэгт өмгөөлөгч оролцох нь үйлчлүүлэгчийнхээ эрхийг тал бүрээс нь бодитой хангах, шүүхийн өмнөх шатанд гарсан процессын алдааг засуулах, ач холбогдолгүй нотлох баримтыг нотлох баримтаас хасуулах зэрэг олон талын ач холбогдолтой.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны гол зорилт бол гэм буруугүй хэнийг ч гэмт хэрэг үйлдсэн гэж гэм буруутайд тооцохгүй байх, хүний эрхийг хамгаалах, зөрчигдсөн эрхийг сэргээх явдал юм. Тэгэхээр энэ зорилтыг хангахад урьдчилсан хэлэлцүүлгийн гүйцэтгэх үүрэг чухал. Гэтэл төрийн бүх механизм улсын яллагчийн талд ажилладаг, ийм нөхцөлд шүүгдэгч, түүний өмгөөлөгч болон ялагч талын тэнцвэртэй байдлыг хангах, хэргийг шударгаар хэлэлцэх зарчмыг нэг мөр хэрэгжүүлэх шаардлагатай. Энэ үүднээс авч үзвэл шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг нь нотлох баримтыг зөв бүрдүүлсэн эсэх, нэмж ажиллагаа хийх шаардлагатай эсэх гээд маш олон асуудлыг хэлэлцэх боломж олгож байгаагаараа давуу талтай. Гэвч энэ заалт бодит утгаараа хэрэгжихэд саад болж байгаа зүйл бол Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 33.1.1-т урьдчилсан хэлэлцүүлгээр хэлэлцэхээр заасан хүсэлт, гомдлыг шийдвэрлэх боломжгүй бол хэлэлцэхгүй орхиж, анхан шатны шүүх хуралдаан руу шилжүүлнэ гэсэн заалт юм. Энэ нь үндсэн нотлох баримт, нэмэлт ажиллагаатай холбоотой асуудлыг урьдчилсан хэлэлцүүлгээр хэлэлцэхгүй байх боломжийг нээсэн. Гэтэл энэ хуулийн заалтыг баримтлаад урьдчилсан хэлэлцүүлгээр үүнийг хэлэлцэх боломжгүй гэж үзсэн хэр нь гэм буруугийн хурал дээр энэ асуудлыг шийдэхгүйгээр шууд гэм буруугийн асуудал руу орж шийддэг. Үүний улмаас шударга шүүхээр шүүлгэх эрх бүхэлдээ зөрчигдөхөд хүрч байна. Тиймээс тус заалтыг боловсронгуй болгох шаардлагатай. Ер нь урьдчилсан хэлэлцүүлгийг тусад нь бүлэг болгож, илүү нарийвчлан зохицуулах нь зүйтэй.

Хоёр. СУДАЛГААНЫ ТОЙМ

Шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг практикт хэрхэн хэрэгжиж байгаа талаар 2020 онд бодлогын судалгаа хийсэн. Өмнө нь 1949, 1963 оны Эрүүгийн байцаан шийтгэх хуульд уг ажиллагаа нь “бэлтгэл цуглаан” гэсэн нэртэй байсан. Уг цуглааныг хийх хоёр үндэслэл байсан бөгөөд зүйл ангийг зөвшөөрөөгүй, таслан сэргийлэх арга хэмжээг өөрчлөх талаар санал зөрөлдөөнтэй үед бэлтгэл цуглаанаар шийдвэрлэхээр зохицуулсан байжээ. 2017 оны Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 33.1-р зүйлийн 6-д нийт 17 үндэслэлээр шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг явуулж болохоор заасан.

Шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг жилд хэдэн удаа болдгийг прокурорын байгууллагын мэдээнд тулгуурлан баримжаалсан. Жилд анхан шатны шүүхээр 12,000 орчим эрүүгийн хэрэг шийдвэрлэгддэг бөгөөд 5,400 орчим хэрэг дээр шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг хийлгэх хүсэлт гаргадаг байна. Сонирхолтой нь эдгээрийн 14 хувьд л шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг хийхээр шүүх шийддэг бөгөөд жилд дунджаар 730-800 орчим хэрэг дээр шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг хийдэг. Урьдчилсан хэлэлцүүлэг хийгдсэн хэргийн 45 орчим хувь нь мөрдөн байцаалтад буцсан байна.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх явцад мөрдөгч, прокурор нь эрүүгийн процессын турш бүхэл бүтэн механизмтай, хуулиар олгогдсон эрхтэй, хүч хэрэгсэл ашигладаг, хүний эрхэд халдах олон төрлийн ажиллагаатай байдаг бол өмгөөлөгчийн хувьд нотлох баримт цуглуулж, тодорхой

үйл ажиллагаа явуулах эрхгүй бөгөөд хүсэлт, гомдол гаргахаар л хязгаарлагддаг. Тиймээс ийм ялгаатай нөхцөл байдалд эрүүгийн процесс дахь тэнцвэрийг хангах гол хэрэгсэл бол шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг бөгөөд энэ нь тус хуулийн нэг чухал үзэл баримтлал юм. Өмгөөлөгчид урьдчилсан хэлэлцүүлгийн ач холбогдлыг өндөр үнэлдэг. Гэвч судалгааны дүнгээс харахад хуулийн анхны үзэл санаа хэрэгжихгүй байна.

Шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг хийлгэхээр гаргасан хүсэлтийн 54 хувийг яллагдагчийн өмгөөлөгч, 10 хувийг хохирогчийн өмгөөлөгч, 5 хувийг прокурор гаргасан бол 31 хувийг шүүх санаачилжээ. Шүүхийн санаачилгаар хийхээр байгаа хуулийн зохицуулалтыг эргэж харах шаардлагатай гэж судлаачид дүгнэсэн. Учир нь шүүхийн санаачилгаар хийж байгаа гол шалтгаан бол их олон хавтаст хэрэгтэй, ээдрээ төвөгтэй хэргийг уншиж, танилцах цаг зав хомсоос болж байна хэмээн судалгаанд хамрагдсан хуульчид үзсэн. Прокурорын хувьд шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг нь ажлынх нь үзүүлэлтэд ихээхэн нөлөөлдөг тул хүсэлт хамгийн бага гаргадаг. Өөрөөр хэлбэл, мөрдөн байцаалтад хэрэг буцах нь прокурорын ажлын тааруу үзүүлэлтийн нэг болж явдаг. Тиймээс шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг хийх эрмэлзэл, сонирхол прокурорт байхгүй. Шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэгт таагүй ханддаг болохоо судалгаанд оролцсон прокурорууд тэмдэглэсэн.

Шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийн 60 орчим хувьд нь өмгөөлөгч оролцоогүй байна. Энэ нь яллагдагчийн өмгөөлүүлэх эрх бүрэн хангагдаж байгаа эсэхэд эргэлзээ төрүүлж байгаа юм. Мөн хуульд шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг хийх 17 үндэслэл заасан ч хамгийн нийтлэг хийгдэж байгаа буюу урьдчилсан хэлэлцүүлэг хийсэн нийт тохиолдлын 41 хувийг нотлох баримт бэхжүүлэхдээ хуульд заасан үндэслэл, журам зөрчсөн тухай асуудал, үүний дараа таслан сэргийлэх арга хэмжээтэй холбоотой асуудал эзэлж байна.

Шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийн үеэр прокуроруудын нэлээд шүүмжлэлтэй хандаж байгаа өөр нэг зүйл бол хэлэлцүүлгийг гэнэт зарладаг, ямар асуудлаар хэлэлцүүлэг хийх гэж байгаагаа урьдчилж мэдэгддэггүй гэжээ. Өөрөөр хэлбэл, “сюрприз барьдаг” гэж тэд үзсэн. Үүнээс үүдэн шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэгт бэлтгэх цаг хугацаа хангалтгүй байдаг байна. Мөн зарим хуульчид шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийг хэргийн явцыг удаашруулах нэг алхам, эсвэл зүйлчлэлийг өөрчлүүлэх оролдлого гэж дүгнэж байгаа нь анхаарал татсан. Энэ нь холбогдох талууд шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийн гол үзэл санааг сайтар ойлгоогүй байгааг илтгэнэ. Шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгээр оролцогчийн эрхийг зөрчсөн, нотлох баримт хууль бусаар бэхжүүлсэн, эрүүдэн шүүсэн, айлган сүрдүүлж мэдүүлэг авсан зэрэг асуудлыг хэлэлцэж, нотлох баримтыг хүчингүйд тооцуулах, тодорхой ажиллагаа хийлгүүлэх асуудлыг шийдэх боломжтой хэмээн өмгөөлөгчид үзэж байгаа нь сайшаалтай.

Гурав. ШҮҮХИЙН УРЬДЧИЛСАН ХЭЛЭЛЦҮҮЛГИЙН ТОВ ТОГТООХ, ӨМГӨӨЛӨГЧ ОРОЛЦУУЛАХ АСУУДАЛ

Шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийн товыг прокурор, өмгөөлөгчийн саналыг харгалзан шүүх тогтоож, урьдчилсан хэлэлцүүлэг явуулахаас 3-аас доошгүй хоногийн өмнө оролцогчид мэдэгдэнэ.

ЭХХШТХ-ийн 33.1 дүгээр зүйлийн 9

“Урьдчилсан хэлэлцүүлгийн товыг шүүх гурваас доошгүй хоногийн өмнө оролцогчид мэдэгдэнэ” гэсэн хуулийн заалт зөрчигдөж байна. Шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг хийхдээ тов тогтоодоггүй, товоо өөрчилбөл мэдэгддэггүй, эсвэл ямар асуудлаар хэлэлцүүлэг хийх гэж байгаагаа мэдэгдэхгүйгээр сюрприз барьж байна гэх шүүмж байна. Цагдан хорионы хурлын товыг бол хоёр, гурван цагийн өмнө л хэлдэг. Өмгөөлөгч чадвал хар хурдаараа ирнэ, зарим тохиолдолд өөр газар хуралтай байж таарвал өмгөөлөгчгүйгээр хуралддаг. Шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийн 60 гаруй хувьд өмгөөлөгч оролцоогүй байгаа асуудал бол урьдчилсан хэлэлцүүлгийг тулгаж зарладагтай холбоотой. Зарлаад өмгөөлөгчид ямар нэгэн байдлаар мэдэгддэг ч тухайн нөхцөл байдлаас хамаараад ирэхгүй байх нь урьдчилсан хэлэлцүүлгийг хойшлуулах үндэслэл болохгүй

гэсэн зарчмаа бариад өмгөөлөгчгүй хийж байна. Гэтэл өмгөөлөгчгүй явж байгаа тохиолдолд оролцогчид эрх, ашиг сонирхлоо хэрхэн хамгаалахаа мэдэхгүй байж байгаад дараагийн шат руу явчихдаг. Энэ нь урьдчилсан хэлэлцүүлгийг хэлбэрийн төдий болгож, улмаар эрүүгийн процесс дахь хүний эрхийн зөрчлийг үл авч хэлэлцэхэд хүргэж байна. Энэ тохиолдолд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.13-р зүйлийн дагуу зөрчигдсөн эрхээ сэргээлгэхээр шүүхэд хандаж болох юм.

Ташрамд хэлэхэд, дэлхийн улсуудад өмгөөлөгч нь мөрдөгч болон прокурортой зэрэгцээд хавтаст хэрэг бүрдүүлж ажилладаг. Шүүх хурал болоход шүүгч ганцхан мөрдөгчийн цуглуулсан хавтаст хэргийг уншиж шийддэггүй. Мөрдөгчийн цуглуулсан баримт материалыг прокурорууд урдаа тавиад, мөн өмгөөлөгч өөрийнхөө цуглуулсан баримт материалыг урдаа тавьж байгаад мэтгэлцдэг энэ тогтолцооны давуу талыг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиар бүрдүүлчихээд байхад өнөөдөр манай өмгөөлөгчид зөвхөн мөрдөгчийн цуглуулсан нотлох баримт, прокурорын хавтасласан материалыг уншиж байгаад, нэг ёсондоо хүний хийсэн ажлыг харж байгаад эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцож байгаа нь нэн харамсалтай. Өмгөөлөгч шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг дээр “Ийм ажиллагаа хийгээгүй, хүний эрхийг зөрчсөн” гээд гомдол гаргаж байгаа ч баримт гаргаж өгөх тал дээр идэвхгүй байдаг нь шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгээр олон чухал асуудал шийдвэрлэхэд саад тотгор болдог.

Нийт хэлэлцүүлгийн 60 гаруй хувь өмгөөлөгчгүй байгаагийн гол шалтгаан бол “оролцуулж болно” гэх зохицуулалттай холбоотой, тиймээс өмгөөлөгчийг заавал оролцуулж байх зохицуулалтыг хуульд тусгавал маргаан гарахгүй. Өөрөөр хэлбэл, “Өмгөөлөгч хүндэтгэн үзэх шалтгаантайгаас бусад тохиолдолд шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэгт ирж оролцоно, оролцох үүрэгтэй” гэж өмгөөлөгчийг үүрэгжүүлээд, нөгөө талаасаа шүүхийг бас оролцох боломжоор нь хангахаар хуульчлаад өгвөл ихээхэн ач холбогдолтой. Мөн “Гурваас доошгүй хоногийн өмнө оролцогчид мэдэгдэнэ” гэснийг зөрчвөл хэрхэх талаар хариуцлагын асуудлыг хуульд тусгах нь зүйтэй.

Дөрөв. ЭРҮҮГИЙН ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛЬД ОРСОН НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ

ЭХХШТХ-д 2022 оны 6-р сарын 3-ны өдөр орсон нэмэлт, өөрчлөлт нь урьдчилсан хэлэлцүүлгээр хэлэлцэх зарим асуудлыг гэм буруугийн хуралдаанд оруулж хуулийн анхны зорилтыг сулруулсан байсныг залруулах алхам болсон. УИХ-ын гишүүн Б.Энхбаяр нарын өргөн барьсан ЭХХШТХ-ийн нэмэлт, өөрчлөлт нь зөвхөн шүүхээс хэргийг буцаах асуудлыг халаад зогсолгүй, үүнтэй холбоотой зарим зохицуулалтыг нэмж оруулснаараа ач холбогдолтой.

Энэхүү нэмэлт, өөрчлөлтөөр хууль бусаар цуглуулсан нотлох баримт, хууль бус нэгжлэг, үзлэг хийж хурааж авсан битүүмжилсэн эд хөрөнгө, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явц дахь хүний эрхийн зөрчил, эрүү шүүлт тулгасан асуудлыг гэм буруугийн хурал руу шилжүүлэх биш, харин шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгээр шийдвэрлэхээр тогтоосон.

Өмнө нь дээрх асуудлыг шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийн үеэр гаргаж тавьсаар байхад шүүгч уг асуудлыг гэм буруугийн хурлаар шийдүүлэхээр шилжүүлдэг байсны улмаас эрүү шүүлт тулгаж цуглуулсан нотлох баримтын асуудлыг шийдэхгүйгээр гэм буруугийн асуудлыг шийдэж, ял оногдуулж байсан нь хуулийн завхрал болсон юм. Тиймээс шинэ нэмэлт, өөрчлөлтөөр шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг дээр өмгөөлөгч эрүү шүүлт тулгаж нотлох баримт цуглуулсан гэсэн асуудлыг гаргаж тавихад прокурор үгүйсгэж чадаагүй бол тухайн нотлох баримтыг хэргээс хасуулж хэргийг буцаах, эсхүл эдгээр нотлох баримт хүчингүй гэж тооцчихоод гэм буруугийн хурал руу шилжих болсон.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны нэлээд хүчтэй, эн тэнцүүхэн оролцогч байх ёстой өмгөөлөгч энэ процесст идэвхгүй байр суурьтай оролцож байгаа нь хуулийн хэрэгжилтэд сөргөөр нөлөөлж байна. Тухайлбал, шинээр орсон нэмэлт, өөрчлөлтийг прокурор, шүүх юу гэж ойлгож, хэрэгжүүлэх бол гэж харахаасаа илүү өмгөөлөгчид уг заалтыг хэрэгжүүлэхийн төлөө шахаж шаардан, идэвхтэй ажиллах ёстой. Тэгж байж эдгээр нэмэлт, өөрчлөлтийн үр дүн гарна.

Тав. ШҮҮХИЙН УРЬДЧИЛСАН ХЭЛЭЛЦҮҮЛЭГ ХҮНИЙ ЭРХИЙН БАТАЛГАА БОЛЖ ЧАДАЖ БУЙ ЭСЭХ

Шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийг 2017 оны Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд оруулснаар хүний эрх, ялангуяа эрүүгийн процесст оролцож байгаа талуудын эрх, ашиг сонирхлыг хамгаалахад тун чухал алхам болсон гэж үздэг. Гэвч олон хүчин зүйлээс шалтгаалаад сонгодог утгаараа хэрэгжих боломжгүй нөхцөл байдлууд бий болсон. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан 10 орчим зарчим бодитой хэрэгжиж байгаа эсэхийг шалгаж үзэх арга бол оролцогчдын тэгш байдлыг хангасан шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг юм. ХЭҮК-т ирсэн гомдлуудын 30 орчим хувийг эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад оролцогчдын эрх зөрчигдсөн тухай гомдол эзэлдэг. Үүнийг задлаад үзэхээр урьдчилсан хэлэлцүүлгийн явцад шалгах ёстой 10 гаруй үндэслэлийг тогтоогоогүй, хянаагүй, хүсэлт гомдлыг шийдвэрлээгүйтэй холбоотой байна. Шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийн шатанд өмгөөлөгч талын оролцоо, тэдгээрийн гаргаж байгаа санал хүсэлтийг шийдвэрлэх тал дээр үр нөлөөгүй байна.

Шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийг “хийж болно, хийхгүй ч байж болно”, “Өмгөөлөгчийг оролцуулж болно, оролцуулахгүй ч байж болно” гэх заалтууд нь энэ зохицуулалтын үр нөлөөг бууруулж байна. Цаашдаа энэ зохицуулалтыг бие даасан бүлгээр зохицуулах шаардлагатай. Шүүхийн ачаалал нэмэгдсэнээс үүдэлтэйгээр нэг хэргийг хоёр, гурван удаа шүүхээр хэлэлцэх нь зохимжгүй гэсэн асуудал яригдаж байгаа ч тодорхой нөхцөл байдал бүхий хэргүүд дээр заавал хэлэлцдэг байх нь хэргийг шүүхээс мөрдөн байцаалтад буцаахгүй байх зохицуулалттай уялдаж, олон сөрөг үр дагавраас урьдчилан сэргийлэх боломж бүрдэнэ. Шүүхээс хэргийг хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтад буцаахгүй байх зохицуулалт нь маш олон хүнд ял завшуулна гэх шүүмж дагуулж байна. Үүнээс урьдчилан сэргийлэх гол механизм бол шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг юм.

Шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг дээр мэтгэлцэх боломжтой байснаар нотлох баримтын шаардлага хангах эсэх, цагдан хорих үндэслэл байгаа эсэх, эрүүдэн шүүсэн эсэх, хүний эрх зөрчсөн эсэх зэрэг олон асуудлыг хянан хэлэлцсэнээр эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны шударга байдал хангагдаж, хүний эрх зөрчигдөхгүй байх баталгаа болох учиртай. Учир нь шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг бол мөрдөн шалгах ажиллагаа шударга, хуульд нийцсэн эсэхийг шалгаж байгаа процесс юм. Хуулийн зохицуулалтыг нарийвчлахын зэрэгцээ холбогдох талууд, тухайлбал, Монголын хуульчдын холбоо, Монголын өмгөөлөгчдийн холбоо, Хүний эрхийн Үндэсний Комисс шүүхийг шахаж ажиллах шаардлагатай. Шүүх урьдчилсан хэлэлцүүлэг хийх журмаа гаргаад, үүн дээр хуульчдын сайн дурын, мэргэжлийн холбоод нь санал, зөвлөмж өгөөд ажиллах боломжтой. Бусад орны туршлага ч ийм л байна. Өөрөөр хэлбэл, шүүхийг шахах ёстой, “Тогтоосон гурван хоногийн хугацаандаа товоо мэдэгд, ямар асуудлаар хэлэлцүүлэг хийхээ урьдчилан мэдэгд, энэ хүрээндээ хэлэлцүүлгээ хий” гэдгийг шахаж шаардах ёстой. Хуулийн үзэл санааг хэрэгжүүлэх шатанд гажуудуулаад байгаа учир сургалт, зөвлөмжөөр үүнийг засаж болно. Мөн хуульчийн мэргэжлийн ёс зүйг төлөвшүүлэх, хандлагыг өөрчлөх асуудалд ч анхаарах нь зүйтэй.

Шүүхийн санаачилгаар урьдчилсан хэлэлцүүлэг хийх асуудлыг бодолцож үзэх шаардлагатай. Хэргийн оролцогчдын хүсэлтээр хийх асуудлыг хуульчилбал энэ хүрээнд гарч буй маргаан гарахгүй байх боломжтой. Гэвч “Шүүх санаачилгаараа хэлэлцүүлэг хийж болно” гэх зохицуулалтыг хасах эсэхийг сайтар тунгааж, талуудтай хэлэлцэж байж шийдэх нь зүйтэй.

Зургаа. ШҮҮХИЙН УРЬДЧИЛСАН ХЭЛЭЛЦҮҮЛГИЙН ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН АСУУДАЛ

Шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг ямар дэгээр явах, хэлэлцүүлгийг шүүх хуралдааны танхимд хийх үү, шүүгчийн өрөөнд хийх үү зэрэг асуудал мөн л анхаарал татаж байна. Нөгөө талаас шударга шүүхээр шүүлгэх эрхийн гол баталгаа бол хөндлөнгийн ажиглалт, дүгнэлт байдаг. Тиймээс хөндлөнгийн ажиглагч, хүний эрхийн шинжээч, мэргэжилтэн, тухайн хэрэгт оролцоогүй өмгөөлөгч шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг хэрхэн явагдаж байгааг хөндлөнгөөс ажиглах нь чухал ач холбогдолтой. Гэтэл оролцогчид нь ч хурлын товоо хангалттай хугацааны өмнө мэдэж, хэлэлцүүлэгт бэлтгэлтэй оролцож чадахгүй байгаа үед хөндлөнгийн ажиглагчдын тухай ярих боломж хумигдаж байна. Энэ хүрээнд “Хөндлөнгийн ажиглагч хэлэлцүүлгийг хэрхэн ажиглах вэ? Оролцож ажиглах боломж, бололцоо хэр байгаа вэ?” гэсэн асуулт урган гарна. Тиймээс бид зохион байгуулалтын шинжтэй энэ зүйлийг ярих нь зүйтэй.

Шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийн үеэр маргаан, мэтгэлцээн гарах ямар ч боломжгүй байна. Мөн техник хэрэгслийн асуудал, тухайлбал, нотлох баримт бэхжүүлэхдээ ийм алдаа гаргасан гээд ярих гэхээр техник хэрэгсэл байхгүй. Өөрөөр хэлбэл, энэ мэдүүлгийг ингэж авсан, гарын үсгийг хуурамчаар үйлдсэн, эсвэл дараа нь өөр мөрдөгч зурсан, нөхөж зурсан гэх мэт асуудал дээр маргадаг. Гэтэл техник технологийн боломж бүрдүүлэх асуудлаа шүүх шийдэхгүй байна. Дараагийн нэг асуудал бол “кэйс менежмент” буюу “хэргийн хөдөлгөөний менежмент” гэдэг зүйл нэвтрүүлэх тухай асуудал юм. Тухайлбал, урьдчилсан хэлэлцүүлэг хийлээ гэж бодоход ямар асуудал хэлэлцэх гэж байгаагаас хамаарч хэлэлцэх асуудал, үйл баримтыг хоёр талд зэрэг явуулдаг. Хэргийн хөдөлгөөний менежмент гэдэг нь дарга нарыг мэдээллээр хангадаг биш, оролцогчдыг мэдээллээр хангаж, урьдчилсан хэлэлцүүлэг хийх нөхцөл бүрдүүлдэг системийг хэлнэ. Үүний дүнд прокурор, шүүгч, өмгөөлөгчийн ачаалал буурах боломжтой. Бид эдгээр асуудлыг шийдэж чадвал шүүхийн маш олон процессыг хялбаршуулах боломжтой. Бусад орны сайн туршлага ч ийм байна.

Шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг хаана болох нь танхимаас хамаарах бөгөөд өнөөдрийн практикаас харахад танхим хүрэлцээ муутай. Магадгүй 11 цагт зарлагдсан урьдчилсан хэлэлцүүлэг “Өмнөх хурал дуусахгүй байна” гэсэн шалтгаанаар тодорхойгүй хугацаанд хүлээлгэх нь энгийн л асуудал. Тиймээс өрөө тасалгааны хүрэлцээг нэмэгдүүлэхэд анхаарах шаардлагатай.

Мөн өөр нэг анхаарах асуудал бол шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийг шүүгч дангаараа удирдан явуулдаг. Өнөөдөр эрүүгийн процессын хуульд найман жил хүртэлх ялтай хэргийг шүүгч дангаараа явуулна, найман жилээс дээш хорих ялтай хэргийг бүрэлдэхүүнтэйгээр шийднэ гэсэн зохицуулалттай. Гэтэл 33-р бүлэгт заасан 17 асуудлыг хэлэлцэхэд зарим асуудалд хамтын шийдвэр чухал юм.

Шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийн хэлбэр, зохион байгуулалтын хувьд “Яг шүүх хурал шиг явуулах уу?” гэсэн асуудал үүднэ. Эндээс нэг хэрэг дээр хоёр шүүх хуралдаан явж байна гэсэн асуудал ч яригддаг. Хамгийн гол нь мөрдөн шалгах ажиллагааны явцад цугларсан нотлох баримтыг нотлох баримтаар тооцох эсэх, энэ нь хэрэгт ач холбогдолтой байсан уу, үгүй юү гэдгийг шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийн явцад эцэслэн шийдвэрлэдэг. Өмгөөлөгч, оролцогч талууд урьдчилсан хэлэлцүүлэг дээр өөр өөрсдийн хамгийн чухал баримтуудыг гарган өгч, хэрэг цаашаа үргэлжилнэ. Урьдчилсан хэлэлцүүлгийн явцад хоёр тал хоорондоо мэтгэлцээд байвал дуусахгүй, нэг мөр сунжирсан асуудал болно. Тэгэхээр урьдчилсан хэлэлцүүлэг дээр өмгөөлөгч шалгуулах шаардлагатай нэмэлт нотлох баримтуудаа бодитой гаргаж өгөөд, баримтуудыг яаж шинжлэн үзэх, тухайн асуудлын үндэслэл, тайлбарыг гаргадаг процесс оруулж өгөх юм бол шүүхийн шийдвэрт аль ч тал ерөнхийдөө гомдолгүй байх, шийдвэрийг хүлээн зөвшөөрөх хандлагад шилжинэ. Урьдчилсан хэлэлцүүлгийн үеэр гаргаж өгсөн нотлох баримтыг үнэлээгүй буюу судлаагүй, шинжлээгүйтэй холбоотойгоор давж заалдаж хяналтын шатанд оруулаад сүүлдээ шинээр илэрсэн нөхцөл байдал гэж үзэх нөхцөл бүрдээд байна.

ШИЙДВЭРЛЭХ АРГА ЗАМ

- * Шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг нь хүний эрхэд суурилсан, шударга эрүүгийн процесс бий болгох чухал баталгаа болохын хувьд түүнийг бие даасан бүлгээр, нарийвчлан зохицуулах;
- * Шүүгч санаачилгаараа шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг хийж буйг нарийвчлан судлах замаар эцэслэн шийдвэрлэх;
- * Шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийн товыг хуулийн хугацаанд мэдэгдээгүй тохиолдолд хүлээлгэх хариуцлагыг тогтоох;
- * Шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг явуулах танхим, техник технологийн боломж бүрдүүлэх, хэргийн хөдөлгөөний менежмент нэвтрүүлэх;
- * Өмгөөлөгчид Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.13-р зүйлийг баримтлан үйлчлүүлэгчийнхээ эрх ашгийг хамгаалах;
- * Хуулийн үзэл баримтлалыг нэг мөр таниулах сургалт зохион байгуулах, шаардлагатай зөвлөмж, удирдамж батлах.

ХЭЛЭЛЦҮҮЛЭГТ ОРОЛЦОГЧДЫН НЭРС

1. Ц.Лхагвацэнд - ХЗДХЯ, Хууль зүйн бодлогын газрын мэргэжилтэн
2. Н.Манлайбаатар - Судлаач
3. Г.Наранбаатар - МХХ-ны зөвлөлийн гишүүн, өмгөөлөгч, хууль зүйн ухааны доктор (Ph.D), дэд профессор
4. Д.Оросоо - МӨХ-ны гишүүн, өмгөөлөгч
5. Г.Оюунболд - МХХ, Эрүүгийн эрх зүйн хорооны тэргүүн
6. Б.Энхболд - ХЭҮК-ын гишүүн, хууль зүйн ухааны доктор (Ph.D), дэд профессор
7. Г.Эрдэнэбат - Хуульч

Хэлэлцүүлгийг хөтөлж,
тэмдэглэлийг сийрүүлсэн
Б.ХИШИГСАЙХАН,
ННФ-ын Эрхзүйн хөтөлбөрийн
менежер



НЭЭЛТТЭЙ
НИЙГЭМ
ФОРУМ

Хаяг: Монгол Улс,
Улаанбаатар хот-14240,
Сүхбаатар дүүрэг,
Жамьян гүний гудамж-5/1

Утас: 976-76113207
Факс: 976-11-324857
Веб: <http://www.forum.mn>
И-мэйл: osf@forum.mn